



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/95

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.3 хэсэг, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалт, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 2.1.1 дэх заалт, аймгийн Удирдлагын зөвлөлийн 2026 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.7 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, 2023 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөхморьт сумын Эрүүл мэндийн төвийн шүдний кабинетийн хэвийн үйл ажиллагаа явуулахад нэн шаардлагатай багаж, материалын зардалд хөрөнгө гаргасугай.

2. Шаардагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд төсөвлөгдсөн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

